БАТЛАВ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Э.ЭНХБАЯР
2024 оны 5 дугаар сарын 17 өдөр

# НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ ЦАХИЛГААН ШУГАМ СҮЛЖЭЭГ ЗАСВАРЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр — Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| 1. | Төсөл боловсруулах үндэслэл | - Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 6 дугаар тогтоол.<br>- 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 01/01314/23 дугаартай техникийн нөхцөл. |
| 2. | Байршил, эдэлбэр газрын хэмжээ | - Хан-Уул дүүргийн 19 дүгээр хороо, 15-1, 15-2 дугаар байр. |
| 3. | Зориулалт хүчин чадал | - Цахилгаан шугам сүлжээг засварлах ажил. |
| 4. | Одоогийн байдал | - Цахилгааны асуудалтай. |
| 5. | Төсөл гүйцэтгэх хугацаа | - Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацаанд үндэслэл болгоно |
| 6. | Төслийн захиалагч | - Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар |
| 7. | Төсөл боловсруулах үе шат | - Гэмтлийг оношлох.<br>- Тооцоо, судалгаа хийх<br>- Ажлын зураг төсөв боловсруулж батлуулах (Магадлал хийлгэсэн байх) |
| 8. | Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага | - Ойролцоох шугам сүлжээний аюулгүйн зайн стандартыг мөрдөж ажиллах.<br>- Техникийн нөхцөлд тавигдсан шаардлагын дагуу олон улсын чанарын стандарт хангасан тоног төхөөремж кабел материалыг сонгох.<br>- Цахилгаан хангамжийн шугамд одоо холбогдож байгаа хэрэглэгч ба хэтийн төлөвлөлтөөр хэрэглэгчдийг холбох боломжийг бүрдүүлэх.<br>- Төвлөрсөн цахилгаан хангамжийн шугам сүлжээнээс хангагдах. |
| 9. | Төсөл боловсруулахад ашиглах материал | **<u>Монгол Улсын хуулиуд</u>**<br>- Хот байгуулалтын тухай хууль<br>- Барилгын тухай хууль<br>- Эрчим хүчний тухай хууль<br>- Бусад холбогдох хууль<br>**<u>Норм, нормативууд:</u>**<br>- Цахилгаан тоног төхөөремжийн байгууламжийн дүрэм БД 43.101.03<br>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНбд30-01-04<br>- Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм БНбд 3.01-06-90<br>- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм<br>- Бусад холбогдох норм, дүрэм |
| 10. | Төслийн иж бүрдэл | **<u>Баримт бичгийн бүрдэл:</u>**<br>- Одоогийн байдлын судалгаа |

| | | |
|---|---|---|
| | | - Тайлбар бичиг<br>- Зураг төсөв (магадлал хийгдсэн байх)<br>**<u>Зургийн иж бүрдэл:</u>**<br>- Нүүр хуудас (батлагдах)<br>- Зураг төсвийн баримт бичиг. Захиалагчид CD-ний хамт 2 хувийг өгөх<br>- Байршлын схем М:2000<br>- Ерөнхий төлөвлөгөө М1:500-1000 (батлагдах)<br>- Зай хэмжээ М1:200-500<br>- Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага<br>А. Хот байгуулалтын мэдээллийн сангийн стандартыг мөрдөх<br>Б. Хийгдэж буй төслийн дэвсгэр зургийн WGS-848 UTM буюу солбицлын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэх<br>**<u>БУСАД</u>**<br>- Дараах байгууллагуудтай заавал зөвшилцсөн байх.<br>- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба.<br>- Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК.<br>- Холбогдох бусад байгууллагатай. |
| 11. | Эдийн засгийн тооцоо, төсөв | - Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНбД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох |
| 12. | Онцгой нөхцөл | - Улаанбаатар хотын Нэг хот Нэг стандартыг мөрдөх<br>- Цахилгаан шугам сүлжээ болон түүнтэй холбогдох барилга байгууламжийн угсралтын ажил гүйцэтгэхэд эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн дэвшилтэд техник технологи нэвтрүүлэн ашиглах.<br>- Авто замын нэвтрэх хэсэгт төлөвлөсөн инженерийн шугам сүлжээний хонгилын системтэй уялдуулах. |

Баталгаа:

- Үйлвэрийн 1 жилийн баталгааны хуудастай байх.
- Баталгаат хугацаанд цэвэрлэгээ, засвар үйлчилгээг хийх хуваарь ирүүлэх (Багадаа улиралд 1 удаа)

ХЯНАСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Л.ОТГОНБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНГӨНШАГАЙ

БАТЛАВ
УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.ДАГДАН
2023

**ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ**

Дугаар 01/01314/23

2023 оны 10 сарын 13 өдөр Улаанбаатар хот

**Нэг. Ерөнхий мэдээлэл**

| | | |
|---|---|---|
| 1.1 | **Хүсэлтийн дугаар** | *231001181* |
| 1.2 | **Хэрэглэгчийн нэр, регистр:** | *Н.ЭНХСАЙХАН, РД:ХБ58120761* |
| 1.3 | **Хэрэглэгчийн байршил:** | *Улаанбаатар Хан-Уул дүүрэг 1-р хороо Богд жавзандамба гудамж 4 тоот* |
| 1.4 | **Ажил үйлчилгээний зориулалт:** | *Шугам , дэд станц зөөх* |
| 1.5 | **Техникийн нөхцөл олгох үндэслэл:** | *1.5.1) Иргэн Н.Энхсайханы 2023-10-09-ны өдрийн өөрийн байрны 0.4 кВ-ын кабель шугамыг шинэчилэн солих хүсэлт.*<br>*1.5.2) Кабель ашиглалт засварын төвийн 2023-10-10-ны өдрийн кабель шугамын трассын тодруулга, тандалт хийсэн тодорхойлолт.* |
| 1.6 | **Техникийн нөхцөлийн ангилал:** | *Цахилгаан дамжуулах шугам зөөх* |
| 1.7 | **Суурилагдсан хүчин чадал** | *0 кВА ( кВА)* |
| 1.8 | **Хүчдэлийн түвшин** | *380В* |

**Хоёр. Холболтын цэг**

| | |
|---|---|
| 2.1 | 110/10/6 кВ-ын Өмнөд дэд станцаас 6 кВ-ын Хивс фидерийн ХТП-0131 дэд өртөөний 0,4 кВ талаас одоо холбогдсон холболтоор тэжээх. |

**Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:**

| | |
|---|---|
| 3.1 | |

**Дөрөв. Тусгай заалтууд:**

| | |
|---|---|
| 4.1 | Төлөвлөж байгаа барилгажих хэсгийн талбайд орсон дараах цахилгаан дамжуулах кабель шугамуудыг батлагдсан зургийн дагуу трасс өөрчлөн зөөж шилжүүлэх: Үүнд<br>4.1.1) - ХТП-131-ээс өөрийн байрны Тайж 15.1, 15.2-р байрны 0,4 кВ-ын 2 ширхэг кабель шугамыг шинэчилэн солих. |
| 4.2 | Цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугамын зөөх байршлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэн Нийслэлийн барилга, хот байгуулалт |

| | |
|---|---|
| | төлөвлөлтийн газраар батлуулж, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах. |
| 4.3 | Кабель шугамыг шилжүүлэн зөөх хэсэгт байгаа муфтыны байршлын тодруулгыг харьяа ашиглалт засварын төвөөс авч, шугамыг муфтынаас муфтыны хооронд зөөх асуудлыг барилга угсралтын ажлын зураг төслийн шатанд УБЦТС ТӨХК-тай зөвшилцөж гүйцэтгэх. |
| 4.4 | Шинээр татах кабель шугам нь авто зам болон тохижилттой зам талбайгаар хөндлөн гарах тохиолдолд кабелийг ган хоолойнд сувлах ба тохижилттой зам талбайд авах боломжтой хавтан суурилуулах. |
| 4.5 | Батлагдсан зургийн дагуу зөөж шилжүүлэх шугамын трасс өөрчлөгдөх тохиолдолд харьяа ашиглалт засварын төвөөс дахин тодруулга авч УБЦТС ТӨХК-тай зөвшилцөх. |
| 4.6 | Газар шорооны ажил хийж байхдаа кабель шугамыг гэмтээсэн тохиолдолд тухайн кабель гэмтээд зогсохгүй бусад тоног төхөөрөмж гэмтэх, хэрэглэгчдийн цахилгаан хэрэгсэл шатах зэрэг ноцтой зөрчилүүд үүсэх бөгөөд гарсан төлбөрийг буруутай байгууллага ААНэгж, иргэн хариуцна. |
| 4.7 | Угсралтын ажлын явцад тус компанийн харьяа ашиглалт засварын төвөөр хяналт тавиулж холбогдох баримтыг бүрдүүлсэн байх. |
| 4.8 | Шилжүүлэн зөөсөн болон шинэчилсэн цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугам, тулгуур, дэд өртөө бусад тоноглолыг УБЦТС ТӨХК- ийн харьяа ашиглалт засварын төвд актаар хүлээлгэн өгөх. |
| 4.9 | Буусан тоног төхөөремжийг Монгол улсын засгийн газрын 2020 оны 97-р тогтоолын 2.7.2-т заасны дагуу УБЦТС ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд шилжүүлэн өгөх. |
| 4.10 | Зөөж шилжүүлэх цахилгаан дамжуулах шугамын угсралтын зураг төслийг ЦБД-ийн БД 43-101-03-д заасны дагуу зай хэмжээг баримтлан гүйцэтгэх. |
| 4.11 | Газар шорооны ажил эхлэхээс өмнө УБЦТС ТӨХК-ийн харьяа ашиглалт засварын төвд хандаж дахин тодруулга хийлгэх, барилга угсралтын ажлын үед хяналт тавиулж холбогдох баримтыг бүрдүүлсэн байх. |
| 4.12 | УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн шугам дэд станцыг шилжүүлэн зөөх ажлыг харьяа түгээх төвөөр гүйцэтгүүлэх. |
| 4.13 | Кабель шугамын трассыг чагнуулж энэхүү хуудсыг авсанаас хойш 30 хоногт газар шорооны ажил хийгээгүй бол дахин тандалт хийлгэх. |

**Тав. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:**

| | |
|---|---|
| 5.1 | Шугамын "Ажлын зураг төсөл"-ийг тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө хариуцсан нэгж болон бусад шаардлагатай байгууллагуудтай зөвшилцөн, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах. |
| 5.2 | Энэхүү техникийн нөхцөлийн дагуу тавигдах шугам, тоноглолууд нь Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн баталсан "Техникийн шаардлагын тодорхойлолт"-ыг хангасан байх шаардлагатай. Техникийн шаардлагын тодорхойлолтыг www.tog.mn хаягаар орж хууль, дүрэм цонхноос үзэх. |
| 5.3 | Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээн засварлах. |
| 5.4 | "Эрчим хүчний тухай хууль"-ийн 30.1.8-д заасны дагуу өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөремжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, |

| | |
|---|---|
| | баталгаажуулалтыг бүрэн хариуцах ба харьяа түгээх төв болон бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй ашиглалт үйлчилгээний гэрээ байгуулах. |
| 5.5 | "Эрчим хүчний тухай" хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу шугам сүлжээний хамгаалалтын зурвас дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно." |
| 5.6 | Шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм, дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж протокол авсан байх. |
| 5.7 | Цахилгаан угсралтын ажлыг тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагаар Аюулгүй ажиллагааны дүрэм, Техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн дүрмийн дагуу гүйцэтгүүлэх. |
| 5.8 | Цахилгаан эрчим хүчний тооцоог Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн харьяа хэрэглэгчдэд үйлчлэх төвтэй хийх. |

**Зургаа. Бусад:**

| | |
|---|---|
| 6.1 | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18- ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"- ийн 2.17- д заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно. Дараах тохиолдолд олгосон техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд:<br>6.1.1) Техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн тохиолдолд.<br>6.1.2) Холболт хийх цэгийн хүчин чадлаас хэтрүүлэн техникийн нөхцөл олгосон.<br>6.1.3) Техникийн нөхцлийн хүчинтэй байх хугацаанд цахилгааны сүлжээнд холбогдоогүй тохиолдолд.<br>6.1.4) Хугацаа дууссан техникийн нөхцөлөөр зураг төсөл боловсруулах, барилга байгууламж барихыг хориглоно<br>6.1.5) Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгуулах хүсэлтээ гаргана. Хугацаа дууссан техникийн нөхцөлийг хүчингүй тооцно.<br>6.1.6) Техникийн нөхцөлийн олгосон чадлаас хэтрүүлэн чадал ашигласан тохиолдолд. |
| 6.2 | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18- ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.9 -д заасны дагуу 1 жилийн хугацаанд хүчинтэй байна. |
| 6.3 | Техникийн нөхцөлийн хугацааг сунгуулах тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18- ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.13, 2.16-д заасны дагуу зураг төслийг боловсруулан баталгаажуулсан байна. |

Комиссын гишүүд: Т.Мөнхболд

Б.Аззаяа

Н.Пунцагноров

Боловсруулсан: С.Батжаргал




Зургийн масштаб = 1:686 (1 сантиметрт 6.86 метр багтана)

Хэвлэсэн огноо: 2023-09-11

## Орчны тойм



Масштаб = 1: 27084

Координатын систем:

WGS84/UTM 48N

EPSG: 32648

Талбайн хэмжээ: 3159 квадрат метр

Энэхүү кадастрын зураг нь газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ болон гэрээний хамт хүчин төгөлдөр болно.

www.egazar.gov.mn